



МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ
САЙДЫН ТУШААЛ

2004 оны 11 сарын 25 өдөр

Дугаар 61

Улаанбаатар

Гадаадад суралцуулах тухай

Боловсрол, Соёл, Шинжлэх ухааны сайд, Санхүү, Эдийн засгийн сайдын 2001 оны 310/290 дүгээр хамтарсан тушаалаар батлагдсан "Өндөр хөгжилтэй оронд магистрантур, аспирантур, докторантурт суралцагчдын зардлыг санхүүжүүлэх журам"-ын 2.6, Г.Эрдэнэбатыг суралцуулах тухай АНУ-ын Ладолон улсын коллежийн урилга болон нэхэмжлэхийг үндэслэн ТУШААХ нь:

1. Гэндэндарам овогтой Эрдэнэбатыг АНУ-ын Ладолон улсын коллежид англи хэл, уран зохиолын чиглэлээр 1.5 жилийн хугацаагаар суралцуулсугай.

2. Г.Эрдэнэбатын нэг жилийн сургалтын зардлыг 18240 ам.доллараар тооцон Сургалтын төрийн сангаас олгосугай.

3. Боловсрол, Соёл, Шинжлэх ухааны сайд, Санхүү, Эдийн засгийн сайдын 2001 оны 310/290 дүгээр хамтарсан тушаалаар батлагдсан "Өндөр хөгжилтэй оронд магистрантур, аспирантур, докторантурт суралцагчдын зардлыг санхүүжүүлэх журам"-ын дагуу суралцагчтай гэрээ байгуулж, холбогдох төлбөр, тооцоо хийхийг Сургалтын төрийн сан /П.Лхагвасүрэн/-д, энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Шинжлэх ухаан, технологи, дээд боловсролын бодлого, зохицуулалтын газар /М.Баасанжав/-т тус тус даалгасугай.



САЙД

П.ЦАГААН